

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛЫН БАЙГУУЛЛАГУУДЫН
“ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ МОНГОЛ” ЧУУЛГАНААС ДЭВШҮҮЛСЭН
ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН**

2022.10.25

2022 оны 05 дугаар сарын 27-ны өдөр Төрийн Ордонд зохион байгуулагдсан “Хүүхдэд ээлтэй Монгол” хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн чуулганаар бүх салбар, яам, агентлаг, нийслэл, орон нутаг хүүхдийн хөгжил хамгааллын иргэний нийгмийн байгууллагуудаас, хүүхдийн өмнө хүлээх үүргээ хариуцлагатайгаар ухамсарлаж ажиллахаа амлан, тодорхой уриалгуудыг дэвшүүлсэн.

Тус уриалгын дагуу Дархан-Уул аймгийн соёлын байгууллагууд дараах үйл ажиллагаануудыг зохион байгуулж, хэвшил болгон ажиллаж байна.

Дархан-Уул аймгийн Хүүхдийн номын ордон:

НЭГ: Хөшиг нээгдэх бүрд хүргэх үг: ИРЭЭДҮЙН УНШИГЧДЫГ ХӨТӨЛНӨ

Хоёр: Хүүхэд хөгжлийн хувь-ийг бий болгоно

Хүүхдийн соёлын орчныг нэмэгдүүлэх чиглэлээр:

- 2022 онд өөрийн орлогыг хүүхэд, багачуудын сурч боловсрох таатай орчин бүрдүүлэх, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор дулааны тоолуур шинээр суурилуулах, сантехникийн шугам хоолойг бүрэн шинэчлэх, шинэ танхимын засвар үйлчилгээ хийх, тоног төхөөрөмж техник хэрэгслээр хангах, суудлын тоог нэмэгдүүлэх, үйлчилгээний цагийг уртасгах зэрэг арга хэмжээнд 6 500 000 төгрөгийг 100% зарцуулсан.

Соёл, урлагийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр:

- Уншигч хүүхдүүдийн эрэлт хэрэгцээ шаардлагыг үндэслэн шинээр “Чөлөөт уншлагын танхим”-ыг засч тохижуулан суудлын тоог 20-иор нэмэгдүүлэн анги нийтээрээ болон хэсэг бүлэг, найз нөхөд, баг хамт олноороо номын сангийн үйлчилгээ авах боломжийг нэмэгдүүлэн ажилласнаар уншигчдын тоо 10%-иар өссөн.
- 2022 оны 9 дүгээр сарын байдлаар уншигчдын эрэлт хэрэгцээ, судалгааг үндэслэн 9.407,899 төгрөгийн 195 нэрийн 572 боть номоор сан хөмрөгөө баяжуулсан.

“Тэгш оролцоотой хүүхэд хөгждөг, хөгжсөн хүүхэд хамгаалагддаг” зарчмын хүрээнд:

- Номын сангийн үндсэн үйл ажиллагааны хүрээнд 4737 уншигч шинээр бүртгэгдэж, 31451 ирэгсдэд, 34080 ном, хэвлэлээр үйлчилсэн. Тус Хүүхдийн номын ордонд Дархан-Уул аймгийн Дархан суманд сурч буй ЕБС-ийн нийт /24143/ суралцагчдын 18,9 % нь буюу 4573 хүүхэд, СӨББ-ийн /9795/ суралцагчдын 0.23% нь буюу 23 хүүхэд номын сангийн уншигч болж, уншлага үйлчилгээнд хамрагдсан үзүүлэлттэй байна.
- Гэрээр ном олгох, зөөврийн болон нүүдлийн номын сангийн үйлчилгээг тогтмол хүргэж 2344 уншигчид, 6790 боть номоор үйлчилсэн.
- Ном хэвлэлийг олон нийтэд сурталчлах, ном унших арга барилд төлөвшүүлэх, мэдлэг, авьяас чадварыг нэмэгдүүлэх зорилгоор Соёл Олон Нийтийн 20 арга хэмжээг уламжлалт болон цахим хэлбэрээр зохион байгуулж, давхардсан тоогоор 26074 гаруй уншигч, хэрэглэгчийг хамруулсан.

- Мөн ЕБС-ийн сурагчдын хичээлээс гадуурх чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх, номтой нөхөрлүүлэх, танилцуулах, бие даан сурч боловсроход нь дэмжин туслах, мэдээ мэдээллээр хангах, зөвлөн туслах, хоцрогдол арилгах, ЭЕШ болон бусад уралдаан тэмцээнд оролцоход бэлтгэх зорилгоор Англи хэл, Байгалийн ухаан, Монгол хэл-бичиг, Цахим ном-мэдээлэл, чөлөөт уншлага үйлчилгээний “BOOK & COFFE танхимууд ажиллаж байна. 2022 оны эхний 9 сард төрөлжсөн танхимуудад нийт 1392 уншигч бүртгэгдэж, 9141 ирэгсдэд 9571 лавлагаа мэдээлэл өгч, ном хэвлэлээр үйлчилсэн байна.

Үндэсний өв соёл шингэсэн цахим контентуудыг бүтээхэд бодлогоор дэмжих арга хэмжээний хүрээнд:

Монгол Улсын Засгийн газраас баталсан соёл, урлагийн үйл ажиллагаатай холбогдолтой төсөл хөтөлбөрүүдийг Хүүхдийн номын ордны хэмжээнд хэрэгжүүлж ажиллаж байна. Үүнд:

- Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “МОНГОЛ БИЧГИЙН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР III”, Дархан-уул аймгийг 2022 онд хөгжүүлэх жилийн төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангах арга хэмжээний хүрээнд ХНО-ны нийт ажилтан, албан хаагчид монгол бичгээр нэр хаягаа зөв бичиж сурч, “Миний нэрийн хуудас” монгол бичгийн үзэсгэлэн гаргасан.
- Соёлын баримтат өв /ном хэвлэл/-ийг технологийн дагуу сэлбэн засварлах, сэлбэн засварлалтын картжуулалт хөтөлж баримтжуулах, технологийн дагуу ариутган халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх арга хэмжээний хүрээнд сан хөмрөгийн номын 3,1%-ийг буюу 411 сэлбэн засварлаж, нийт номын 75% буюу 9989 ном ариутгаж халдваргүйжүүлсэн.
- Засгийн газрын 2019 оны 68 дугаар тогтоолоор батлагдсан “Соёлын биет бус өвийг хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах, Соёлын биет бус өвийн талаар хүүхэд багачуудын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор Цагаан сар, Эх хэл аман яруу найраг, Аялгуут аман яруу найраг, Аялгуут бус аман зохиол, Хүүрнэн өгүүлэх аман зохиол, Монгол уран бичлэг, Монгол уламжлалт номын урлал зэрэг нийт 7 зурагт мэдээлэл бэлтгэж, өөрийн пейж хуудсандаа /<https://www.facebook.com/Nomiin.ordon/> байршуулсан. Тус мэдээлэл нийт 2143 хэрэглэгчдэд хүрсэн.

Залуучууд театр

НЭГ: Хөшиг нээгдэх бүрд хүргэх үг: “Бид соёлыг түгээж ирээдүйн соёлтой үзэгчийг бэлтгэнэ”

Хоёр: Хүүхэд хөгжлийн хувь-ийг дараах байдлаар бий болгов. Үүнд:

- Залуучууд театр “Хүүхдийн эрх”-ийг хамгаалах өдрөөр “Энэрэл” цогцолбор сургуулийн сурагчдад “Лануш” хүүхдийн жүжгийг 1 удаа үнэ төлбөргүй тоглож хүүхдийн хөгжилд 1.400.000 төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна.
- 2022.09.19-ний өдөр “Шидэт модны үр” хүүхдийн жүжгийн нээлтэд зориулж 150 ширхэг урилгыг зорилтот бүлгийн хүүхдүүдэд бэлэг болгон барилаа.

Хүүхдийн соёлын орчны таатай орчин, аюулгүй байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр:

- Хүүхэд багачуудын үзвэрийн таатай орчин бүдүүлэх зорилгоор их танхимын дулааны шугам хоолойн засвар шинэчлэлтийн ажлыг хийлээ.

- Хүүхэд багачуудын аюулгүй байдлыг хангах зорилгоор 1 давхрын фоен болон үзвэрийн их танхим, дугуй танхимд гэрэлтүүлгийг нэмэгдүүлж сайжрууллаа.
- Тав тухтай орчныг бүрдүүлэхэд үзвэрийн танхимын хаалга, 1 давхрын фоеины улаан багануудыг иж бүрэн засвар үйлчилгээ хийж өнгө үзэмж нэмэгдүүллээ.

Соёл, урлагийн үйлчилгээний хүртээмж, олон нийттэй харилцах ажлыг нэмэгдүүлэх чиглэлээр:

- Аймгийн Засаг даргын ивээл дор хэрэгжиж буй “Тэрбум модны үр” төслийн хүрээнд “Шидэт модны үр” жүжгийг найруулан тавьж аймгийн нийт ЕБС болон СӨББ –ийн ахлах бүлгийн хүүхдүүдийг хамруулан одоогийн байдлаар нийт 15 удаа тоглогдож, 5800 хүүхэд багачуудад хүргээд байна.
- Дархан хотынхоо 60, 61 жилийн ойд зориулан Дархан хотынхоо үүх түүхийг ирээдүй хойч үе болсон хүүхэд, багачууд, оюутан, залуусаа соён гэгээрүүлэх, түүх ёс уламжлал, төрөлх хотоороо бахархах сэтгэл бий болгох зорилгоор “Домог амилсан нутаг” дуулалт жүжгийг ЕБС-ийн 5860 сурагчдад 18 удаа толилууллаа.

“Тэгш оролцоотой хүүхэд хөгждөг, хөгжсөн хүүхэд хамгаалагддаг” зарчмын хүрээнд:

- Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018.12.03-ны өдрийн 03 дугаар тогтоод гарсантай холбоотой Байгууллагын эцэг эхийн зөвлөлийг Залуучууд театрын даргын 2022.01.25-ны өдрийн №А/02 тоот тушаалаар 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн томилов. Уг бүрэлдэхүүнээр аймгийн Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас ирүүлсэн “Эцэг эхийн зөвлөл байгуулж ажиллах зөвлөмж”-ийн дагуу 2022 онд хийгдэх ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлан ажиллаж байна. Эцэг эхийн салбар зөвлөлийг алба, хэлтэс бүрээс төлөөлөл болгон оруулж 14 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулав.
- Байгууллагын нийт албан хаагчдын хүүхдүүдийн дунд “Талархал” сэдэвт захидлын уралдааныг зохион байгуулан шагнаж урамшууллаа.
- ЗТ-ын эцэг эхийг зөвлөл “Гоцлон бүжиглэхүй” бүжгийн уралдааныг зохион байгууллаа.
- Санхүү албатай хамтран эцэг, эхчүүдийн дунд “АХА” тэмцээн зохион байгууллаа.
- Соёлын хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор нийт 8 төрлийн дугуйлантай хамтран ажиллах гэрээ хийн ажиллаж байна. Үүнд:
 - Дууны дугуйлан -2
 - Драмын дугуйлан -1
 - Хөгжмийн дугуйлан -4
 - Бүжгийн дугуйлан -1
- Залуучууд театрын Bellcanto дууны дугуйлангийн сурагч Х.Отгонзаяа, Б.Бямба-Эрдэнэ нарын хамтарсан “Эгшиглэнт хавар” тоглолтыг дэмжин хамтран зохион байгууллаа.
- Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 03 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхэд албан байгууллага бүр хүүхдийн язгуур эрхийг нэн тэргүүнд тавьж, ажилтан албан хаагчдаа гэр бүл, үр хүүхэддээ цаг гаргахад нь дэмжлэг үзүүлж, хүүхдэд ээлтэй шийдвэр гаргахыг Аймгийн засаг дарга, аймгийн хүүхдийн төлөө зөвлөлийн гаргасан 0-18 хүртэлх насны хүүхэдтэй эцэг эхчүүдэд хүүхдийн “Мэндэлсэн өдөр”-өөр тухайн өдрийн цалинтай чөлөө олгох асуудал дээр мөн хяналт тавьж ажилласан.

Үндэсний өв соёл шингэсэн цахим контентуудыг бүтээхэд бодлогоор дэмжих арга хэмжээний хүрээнд:

- “Хүүхэд хамгааллын бодлогын жишиг баримт бичиг”-ийг байгууллагын нийт ажилтан албан хаагчид болон бусад хүмүүст харагдахуйц газар байрлуулан сурталчлан ажиллаж байна. Хүүхдийн аюулгүй байдлын талаарх хүүхдийн эрхийг хамгаалах мэдээллийн самбарыг байршууллаа.
- 2022.05.09, 10-нд 2 удаа “ӨГЛӨӨНИЙ НАР” тайзны бүтээлийг бидний ирээдүй болсон өсвөр үеийн хүүхэд залуус, тэдний асран хамгаалагч гэр бүлийнхэнд анхааруулах үүднээс үзэгч олондоо өргөн барилаа. Энэхүү бүтээлийг зорилтот бүлэг болох амьдралд хөл тавих насан дээрээ мэргэжлээ сонгох гэж байгаад хүний наймааны хамгийн том золиос болж байгаа 70%-ийг эзэлж байгаа ахлах анги буюу 12-р ангийн хүүхдүүдэд үзүүлэн урьдчилан сэргийлэх, зөв шийдвэрт хүрэхэд нөлөөлөх, эргэн санан бодох нөхцөлийг өгөх зорилготой.
- “Замын хөдөлгөөнд Хүүхэд 1-т” уриалга бүхий зөвлөмжийг бэлтгэн Залуучууд театрын болон бусад мэдээллийн сувгуудаар түгээж ажиллаж байна.
- 2022.03.15-наас 06.10-ны өдрийг хүртэл ЕБС-ийн сурагчдыг өдрийн 3 ээлжээр театрын автобусаар зөөж үйлчилсэн.

Төв номын сан

Хөшиг нээгдэх бүрд хүргэх үг: “ОЮУНЛАГ ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ”

Хүүхэд хөгжлийн хувь-ийг бий болгоно

1. Хүүхдийн соёлын орчныг нэмэгдүүлэх чиглэлээр:

- ✓ Уншигч хүүхдүүдэд ая тухтай орчин бүрдүүлэх зорилгоор салбар номын сангийн байрны, сантехникийн засвар үйлчилгээг хийв.
- ✓ Ном хэвлэлийг чөлөөтэй сурталчлах, шинэ номын мэдээ мэдээллийг шуурхай хүргэх, хэвлэн сурталчлах зорилгоор үзэсгэлэнгийн тавиурыг байршуулав.

2. Соёл, урлагийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр:

- ✓ ГБХЗХГ-тай хамтран Цахим ном төслийг Unitel hub танхимын тоног төхөөрөмжүүдэд 320 гаруй номыг байршуулж, уншигчдад хүргэж байна.
- ✓ Соёлын яамны удирдамжийн дагуу хүүхдэд зориулсан ном хэвлэлээр фонд бүрдүүлэлтийн хүрээнд нийт ном 359 ширхэг, 4 855 000 төгрөгийн ном худалдан авсан. Үүнээс 26 боть 555000 төгрөгний номыг хандиваар, 333 боть 4300 000 төгрөгийн номыг худалдаагаар авч номын фондоо бүрдүүлсэн.

3. “Тэгш оролцоотой хүүхэд хөгждөг, хөгжсөн хүүхэд хамгаалагддаг” зарчмын хүрээнд:

- “ҮЛГЭРЭЭС ҮЛГЭРЛЭЭ” 4 удаа 250 гаруй хүүхэд багачууд оролцов.
- “ЧАНГА УНШЛАГА” 2 удаа 58 хүүхэд
- “УРИЛГАТ УНШЛАГА” нийтдээ 17 удаа 534 сурагч хамрагдлаа

Жил бүр уламжлал болгон Үндэсний бичиг үсгийн баяр, Дэлхийн номын өдөр, Номын баяр зэрэг ном тойрсон тэмдэглэлт өдрүүд болон өдөр тутмын үйл ажиллагааны хүрээнд урилгат уншлага зохион байгуулагддаг билээ.

- “ОЮУНЛАГ ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ” - Нийт 11 ангийн 346 сурагчдад номын санг танилцуулж, цахим номыг ашиглах, номоо хэрхэн захиалж унших талаар зөвлөгөө өгч, номын сангийн үйл ажиллагааны талаар танилцуулж, номын сангаар зочилсон хүүхдүүдэд үнэгүй карт нээж уншигчаар бүртгэв.
- УНШААД УРАГШЛАХУЙ - Оюунлаг Дархан өдөрлөг 5 удаа 497 хүнд 437 боть ном
- УРАН ЗОХИОЛЫН ДҮРИЙН БОЛОН УНШИГЧДЫН ЖАГСААЛ 1 удаа 120 гаруй хүүхэд
- УРАЛДААН 6 удаа 250 хүн оролцсон.

- "Бийрээ нийлье" уран бичлэгийн уралдаан:

Аймгийн Төв номын сан нь Монгол бичиг үсэг, өв соёлоо сурталчилсан төрөлжсөн уралдаан тэмцээн, эрдэм шинжилгээний хурал, уулзалт, ярилцлага, соёл, уламжлалыг харуулсан цуврал үзэсгэлэнгүүд зэрэг олон нийтэд зориулсан төрөл бүрийн арга хэмжээг бүх шатны сургууль болон бусад байгууллагуудтай хамтран зохион байгуулдаг уламжлалтай. Энэ удаагийн БИЙРЭЭ НИЙЛЬЕ уралдаанд шагналт байр 3, тусгай байр 3-ыг шалгаруулсан.

- Номын үзэсгэлэн: 7 удаа 457 боть

Эх үрсийн баярын өдөрт- 35 боть, Эрийн гурван наадам-51 боть, Эх хэлний өдөрт 65 боть номоор, ЭШалгалтанд бэлтгэгчдэд /сурагчдад/-55 боть номоор, Соёл урлагийн ажилтны өдөрт-83 боть номоор, Соёлын өвийн бүтээлийн үзэсгэлэн "Нүүдэлчин Монгол-2022" их наадамд оролцсон багш нарын бүтээл болон "Монгол хүний өв соёл" сэдэвчилсэн номын үзэсгэлэнг - 68 боть номоор тус тус сэдэвчилсэн номын үзэсгэлэн гаргав.

- Нүүдэл зөөврийн номын сан: 6 удаа 630 хүүхдэд 720 боть ном олгож үйлчиллээ.

Аймгийн Музей

Хөшиг нээгдэх бүрд – “ХАЙРЛАГДСАН ХҮҮХЭД ХАМГААЛАГДДАГ”

1. Байгууллага, аж ахуй нэгж нь ажилтан, албан хаагчдынхаа ажил амьдралын тэнцвэрийг хангахад чиглэсэн хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

- Хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийг хамгаалах ажлын хүрээнд холбогдох хууль тогтоомжуудыг Эцэг Эхийн Зөвлөл болон албан хаагчид хамтран судалж, мөрдлөг болгон ажиллаж байна.
- Музейн Эцэг эхийн зөвлөлөөс шаардлагатай гарын авлага, сургалт сурталчилгааг тогтмол явуулж, ажилтан албан хаагчдыг мэдээ мэдээллээр ханган ажилладаг.
- Ажилтан, албан хаагчдыг хүүхдүүдийн төрсөн өдрөөр амраах тухай хуулийн заалтыг дотоод журмандаа тусгаж өгсөн.
- Бага насны хүүхэдтэй ажилтанг богиносгосон цагаар ажиллуулж, цэцэрлэг, сургуулийн хүүхдүүдээ хичээл орох, тарах үед зөөхөд нь ажилчиддаа уян хатан зарчим баримталдаг.
- Хүүхдүүдийн цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагаанд эцэг эхчүүдийг оролцох боломжоор хангах зэрэг ажлуудыг тогтмол биелүүлэн ажиллаж байна.

2. Олон нийт, соёл, спортын арга хэмжээн дэх хүүхэд хамгааллын ажлын хүрээнд:

- Дэлхийн гэр бүлийн өдөр буюу 5 дугаар сарын 15-ны өдөр байгууллагын Эцэг Эхийн Зөвлөлөөс Музейн ажилтан албан хаагчдыг гэр бүлийн хамт “Миний Монгол” цэцэрлэгт хүрээлэнтэй танилцах, Хүүхдийн галт тэргээр аялах аялал болон “Тэшүүртэй бамбарууш” тоглоомын төвд тоглох ажлуудыг зохион байгууллаа. Тус аялалд 8 албан хаагчдын 14 хүүхэд хамрагдсан. Мөн аялалын үеэр хүүхдүүдийн дунд 100м гүйлтийн тэмцээн зохион байгуулж хүүхэд багачуудынхаа 1 өдрийг дурсамжтай өнгөрүүллээ. Тус аялалд шаардлагатай зардал болон аюулгүй байдлыг албан хаагчид өөрсдөө хариуцан Эцэг Эхийн Зөвлөлтэйгээ хамтран ажиллалаа.

3. Эрүүл мэндийн үйлчилгээн дэх хүүхэд хамгаалал, хүүхдийг гэмт хэрэг, зөрчил, ослоос урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд:

- Музейн Эцэг Эхийн Зөвлөлөөс хичээлийн шинэ жил эхэлсэнтэй холбогдуулан “Ахуйн хүрээн дэхь осол гэмтэл, тэдгээрийн үед авах арга хэмжээ” эрүүл мэндийн сургалтыг 31 дүгээр цэцэрлэгийн эмч П.Алтанзултай хамтран зохион байгууллаа. Уг сургалтанд Музейн ажилтан албан хаагчдийн 11 хүүхдүүд хамрагдсан бөгөөд гэмтэл осол болох үед авах арга хэмжээг биечлэн туршилт хийв. Мөн сургалтанд хамрагдсан хүүхдүүдийнхээ дархлааг дэмжин витаминжуулалт, хурууны лент, бинт, зүү тариур зэргийг худалдан авч 70.000 төгрөгийг байгууллагын төсвөөс зарцуулав.

4. Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал, Хүүхдийн хөгжил, оролцоог дэмжсэн ээлтэй орчин бүрдүүлэх ажлын хүрээнд:

- Аймгийн Музей нь сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуультай хамтран хүүхдүүдийг Музей үнэгүй үзүүлэх, олон талт боловсролын хөтөлбөрт хамруулах зэрэг ажлыг тогтмол гүйцэтгэж байна. Одоогийн байдлаар “Оюуны Ирээдүй” цогцолбор, нэгдүгээр сургууль, есдүгээр сургууль, “Монгол оюу” сургууль, 3, 4, 5, 7, 12, 15 зэрэг цэцэрлэгүүд хамрагдаад байна.

Мөн чуулганы үед хэлэлцүүлсэн хэлэлцүүлгийн хүрээнд хүүхдийн эрхийг хамгаалах, хамгаалагдсан орчинг бий болгох зорилгоор байгууллагын дотоод журмандаа нэмэлт өөрчлөлт оруулж 2023 оноос хэрэгжүүлэх, “Хүүхдүүдийг эрэмбэлж нэгийг нь илүү, нөгөөг нь дутуу мэт, шагнал, өргөмжлөл олгохоо больё” уриалгад нэгдэж ажиллахаар бэлтгэж байна. Мөн бусад байгууллагуудад үлгэр жишээ болж уриалан дуудна.

Шарын гол сумын соёлын төв

1. “Хөшиг нээгдэх бүрд-хүргэх нэг үг” уриалгыг хэрэгжүүлж соёл, урлагийн үзвэр, үйлчилгээ, соёл, олон нийтийн ажил бүрийн эхэнд Хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдэд үүргийг сануулсан уриалга хүргэж хэвших ажлын хүрээнд:

- Сумын 60 жилийн ойн арга хэмжээнд оролцсон хүүхдүүдийн асран хамгаалагчдад хүүхдийнхээ аюулгүй байдалд хяналт тавихыг зөвлөсөн.
- Хөгжсөн хүүхэд хамгаалагддаг уриан дор сумын “Алтан намар” нээлттэй хаалганы өдрөөр хүүхдийн хөгжих, хамгаалуулах эрхийг ханган ажиллах зорилгоор боловсролын байгууллагуудад хичээллэх дугуйлан секцийг иргэдэд танилцуулсан.
- Нээлттэй хаалганы өдрөөр иргэд үйлчлүүлэгчдээс сэтгэл ханамжийн судалгаа авч, иргэдэд танилцуулсан.
- Байгууллагын болон ГХУС цахим хуудсуудаар дамжуулан гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль тогтоомж шийдвэр, зурагт хуудас уриалга зэргийг иргэд олон нийтэд хүргэж байна.
- Нэгдүгээрт хүүхэд уриан дор Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлж аж ахуйн нэгж байгууллагууд өөрийн нэрэмжит тэмцээн уралдааныг зохион байгуулж хүүхэд багачуудаа баярлуулсан.

2. “Хүүхэд хөгжлийн хувийг бий болгох” соёл, урлагийн үзвэр, үйлчилгээний худалдаалагдсан тасалбарын орлогын 1 хувийг өөрийн байгууллагын хэмжээнд хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр тодорхой үр дүнд хүрэхүйц төсөл, арга хэмжээнд зарцуулан ажиллах чиглэлээр:

Байгууллагын ажилтан албан хаагчдын 10 хүүхдийг эрүүл мэндийн бүрэн үзлэгт хамруулж, эмчлэн эрүүлжүүлэх ажлыг эхлүүлээд байгаа бөгөөд, “Хүүхдээ сонсоё” арга хэмжээ зохион байгуулж, нийт 273900 төгрөгний зардал гаргасан.

Хонгор сумын соёлын төв

1. “Хөшиг нээгдэх бүрд-хүргэх нэг үг” уриалгыг хэрэгжүүлж соёл, урлагийн үзвэр, үйлчилгээ, соёл, олон нийтийн ажил бүрийн эхэнд Хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдэд үүргийг сануулсан уриалга хүргэж хэвших ажлын хүрээнд:

- Сумын 60,61 жилийн ойн наадмын арга хэмжээнд оролцсон хүүхдүүдийн асран хамгаалагчдад хүүхдийнхээ аюулгүй байдалд хяналт тавихыг зөвлөсөн.
- “Аав ээж би” хөгжөөнт буухиа тэмцээнийг зохион байгуулсан бөгөөд XVI, Чандага цэцэрлэгийн дунд, ахлах бүлгийн хүүхдүүд эцэг эхийн хамт оролцсон.
- Нээлттэй хаалганы өдрөөр аймгийн нийтийн бүжгийн ахмадууд бүжгийн дугуйлангийн хүүхдүүдтэй хамтран бүжиглэсэн.
- ГХУС ажлын хүрээнд “Хүүхдэд ээлтэй Хонгор сум” сэдэвт тэмцээн XIV болон XI сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд амжилттай зохион байгуулагдсан.
- Нэгдүгээрт хүүхэд уриан дор Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлж аж ахуйн нэгж байгууллагууд өөрийн нэрэмжит тэмцээн уралдааныг зохион байгуулж хүүхэд багачуудаа баярлуулсан.
- Сургагч багш Д.Доржналжирмаа “Хүчирхэг охид” сэдэвт сургалт зохион байгуулсан.
- XVI цэцэрлэгийн бэлтгэл бүлэгт үлгэрийн 32 ширхэг ном хандивласан.

2. “Хүүхэд хөгжлийн хувийг бий болгох” соёл, урлагийн үзвэр, үйлчилгээний худалдаалагдсан тасалбарын орлогын 1 хувийг өөрийн байгууллагын хэмжээнд хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр тодорхой үр дүнд хүрэхүйц төсөл, арга хэмжээнд зарцуулан ажиллах чиглэлээр:

“Ойн түүх” хүүхдийн уран сайхны киног соёлын төвдөө гаргасан бөгөөд тасалбарын үнийг 20% хямдруулан хүүхэд багачуудад толилуулсан.

Орхон сумын соёлын төв

Сурагчдын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, сум орон нутгийнхаа онцлогоор бахархах, таньж мэдэх бусдад сурталчлах сурагчдын сэтгэх чадвар, оролцоог нэмэгдүүлж, амьдрах орчноос суралцах чадварыг сайжруулах зорилгоор:

- Хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр хүүхдүүдийн дунд дугуйн спорт, гар зургийн уралдаан, 3х3 сагсан бөмбөгийн тэмцээнүүдийг тус тус зохион байгуулсан.
- Сумын 54 жилийн Үндэсний баяр наадмын арга хэмжээнд оролцсон хүүхдүүдийн асран хамгаалагчдад хүүхдийнхээ аюулгүй байдалд хяналт тавихыг зөвлөсөн.
- Соёлын ажилтны 29 дэх өдрийг тохиолдуулан Орхон сумын хүүхэд багачуудад зориулж шинэ номын үзэсгэлэн, орон нутаг судлах танхимын үзмэрийн үзэсгэлэнг толилуулсан. Мөн дугуйлангуудын өдөрлөг танилцуулга хийж морин хуур, ёочин хөгжмийн дугуйланд сонгон шалгаруулж авсан.
- “Open mic Орхон” (дунд, ахлах ангийн сурагчдын дунд) амжилттай зохион байгуулсан.
- 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн ЕБСургуулийн 6-12 дугаар ангийн сурагчид үдээс өмнө биеийн тамирын хичээл үдээс хойш дугуйлан соёлын төвийн спорт зааланд хичээллэж эхэлж байна.

- Хүүхэд багачууддаа зориулан "ОЙН ТҮҮХ " хүүхдийн үлгэрийн киног соёлын төвдөө гарган сурталчилж ажиласан. Нийт 110 хүүхэд үзсэн.
- Бага ангийн хүүхдүүдэд номын фондоо танилцуулж, номын санч М.Оюунчимэг "Ном уншихад мэдлэг нэмэгдэнэ" сэдвээр сургалт хийсэн.

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР